

АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ЭРХ ЗҮЙН АРГА ЗАМУУД ГАДААДЫН ТУРШЛАГА

В.В. МОСЛОВСКИЙ

Орос хэлнээс орчуулсан: **Чагнаадорж Батчимэг**
ХСИС-н ГХСТ-н ахлах багш, хэл шинжлэлийн
магистр цагдаагийн ахлах дэслэгч

Гэмт хэргээс сэргийлэх болон хууль зөрчигчидтэй харьцах талаар НҮБ-ийн 8-р Конгресс өөрийн гаргасан “Төрийн удирдлагын хүрээн дэх авлига”-ын талаархи тогтоолдоо төрийн захиргаан дахь авлигын асуудал нь бүх нийтийн шинж чанартай байгаа ба муу нөлөөлөл нь бүх дэлхий даяар мэдрэгдэж байна гэж тэмдэглэжээ. Зарим улс орнуудад авлигатай тэмцэж байгаа талаархи тэмцлийн судалгаа нь хуулийн өмнө бүх иргэд тэгш эрхтэй гэж тунхаглаад байгаа зарчим болон эрүүгийн хариуцлагад татах бодит байдал зэргийн хооронд асар том ялгаа байгааг харуулж байна. Авлига- энэ бол цагаан захтнуудын гэмт хэргийн нийтлэг төрөл юм.

Иймээс энэ төрлийн гэмт хэрэг нь маш нуугдмал гэмт хэрэг бөгөөд ихэнхдээ маш их хэмжээний хохирол учруулдаг ба их нарийн боловсруулсан төвөгтэй байдлаараа ялгагддаг. Авлигын онцгой аюул бол төрийн аппаратыг хорт хавдар шиг болгож түүнийг зөвхөн “хирургийн аргаар” л авч хаяж болох тийм буцалтгүй өөрчлөлтөд хүргэдэг. Гэвч хамгийн гол нь авлига-энэ бол зохион байгуулалттай гэмт хэргийг хөгжүүлдэг ба түүний амьдрах орчныг бүрдүүлдэг бүрэлдэхүүнүүдийн нэг нь болдог байна. Нийлээд эдгээр хоёр үзэгдлүүд нь төр ба нийгэмд ялангуяа шинээр төрөн гарч байгаа ардчиллын нөхцөлд хамгийн ноцтой аюул болж байгаа юм. Энэ бүгд нь авлигатай тэмцэх тэмцлийг зохицуулах хууль тогтоомжийг нэн даруй гаргах, зохих хууль тогтоомжуудыг бий болгох шаардлага байгааг тодорхойлж байна. Гэвч энэхүү үзэгдэлтэй тэмцэх тэмцэлд бодит өөрчлөлт маш бага, бараг гарахгүй байна. Эдгээр шалтгаануудын нэг бол дотоодын туршлага байхгүй байгаа байдал юм. Гэсэн ч олон өөр тохиолдлуудад Орос улсын төрд авлигатай тэмцэхэд саад болоогүй юм. Гэвч авлигатай хийх тэмцлийн хүрээ нь: төрийн нэг болгоомжгүй үйлдэл нь төр болон эдийн засагт аюултай резонанс үүсэхэд хүргэж мэднэ. Ийм нөхцөл байдалд бидний одоогийн хүндрэлүүд нь Оросын архидалттай тэмцэх тэмцэл шиг эртний түүхэн уламжлал бүхий урт удаан хугацааны зайлшгүй зүйл байсан улсын туршлага судлах шаардлагатай болж байгаа юм. Түүнээс гадна олон улс орнуудад авлигатай хийх тэмцэлд эерэг үр дүн гарч байна. Ийм туршлага байгаа гэдгийг үзүүлэх явдал бол энэхүү нийтлэлийн зорилго юм.

Төрийн албан хаагчид

Энгийн ойлголтоор бол авлига нь юуны түрүүнд төрийн албатай холбогддог. Авлигын эсрэг хууль тогтоомжуудыг төлөөлөх засаглал ба корпорациудын

захиргааны зэрэг бусад хүрээнд нэвтрүүлэх өнөөгийн хандлага байгаа ч гэсэн төрийн албан тушаалтнуудын хүрээнд авлигатай тэмцэхэд чиглэсэн хуулиуд нь арай илүү дэлгэрэнгүй боловсруулагдсан байна. Үнэхээр төрийн албан хаагчид нь үйл ажиллагааны эрх мэдлийн эрх чөлөөтэй байдаг учраас ихэвчлэн ямар ч хяналтгүйгээр ажиллан өөрсдийн ашиг сонирхолд албан тушаалын байдлаа ашиглах бүх боломж байх бөгөөд улмаар энэ бүхнийг төрийн ашиг сонирхлын эсрэг хэрэглэдэг. Барууны улс орнуудын төрийн албаны тухай хууль тогтоомж нь нэгэн янзын байдгаараа ялгаатай байна. Нэг маягийн хориг саад, хязгаарлалтууд болон анхааруулгууд нь бүх ардчилсан орнуудын хууль тогтоомжуудад байдаг юм. Эдгээр бүх арга хэмжээнүүд нь тэдгээрийг нарийн чанд мөрдсөн үед харьцангуй үр дүнтэй болохыг харуулсан. Энэхүү туршлагыг одоо зүүн европын болон Азийн орнууд сонирхож байна. Удирдлагын аппаратын хэмжээгээр нь Оростой харьцуулсан ардчилсан орнуудын төрийн албаны зохион байгуулалтын судалгаа нь сонирхолтой байна. Тэдгээр улс орнуудын тоонд: АНУ, Канад, Герман, Франц ба Их Британи зэрэг улсууд байна. Гэвч Англи ба Франц зэрэг улсуудад уламжлалын элемент нь ихээхэн байдаг учир үндэсний онцлогууд нь тэдгээрийн туршлагыг бүрэн хэмжээгээр нь ашиглах боломж олгохгүй байна. Эдгээр улс орнуудын түшмэлүүд нь онцгой, хангалттай хэмжээгээр тусгаарлагдсан үе давхаргыг үүсгэн төрийн албаны бэлтгэл ба боловсролын тусгай системийг бий болгосон байдаг бөгөөд өөр бусад онцлогууд ч байдаг байна. Харин АНУ, Герман ба Канад зэрэг улс орнуудын туршлага нь Орос орны нөхцөлд хэрэгжиж болохоор байна.

1990 оны 10-р сарын 17-нд АНУ-ын Ерөнхийлөгчийн гүйцэтгэх тушаал №12731-д гарын үсэг зурсан байна. Энэхүү тушаал нь өмнө нь гаргасан байсан хууль боловч түүнийгээ шинэчлэн сайжруулсан хуулийг баталсан тушаал бөгөөд энэхүү хуулийн тусламжтайгаар АНУ-ын төрийн албан хаагч бүх хүмүүсийн, засгийн газрын гишүүд ба төрийн албан хаагчдын биеэ авч явах ёс зүйн заавал мөрдөх нийтлэг зарчмыг мөрдөхөөр болгосон. Үндсэндээ бол тухайн зарчмууд өндөр зэрэглэлийн албан тушаалтнууд болон төрийн энгийн албан хаагчдад тавьж байгаа, тодорхой болгосон хууль зүйн болон ёс зүйн шаардлагууд юм.

Энэхүү тушаалд “Хүлээсэн үүргээ чин сэтгэлээсээ биелүүлэхэд саад тотгор болж байгаа ямар нэгэн хувийн эсвэл бусад санхүүгийн сонирхлыг үйл ажиллагааныхаа хүрээнээс зайлуулан ажиллах ёстой салбар гэж төрийн албыг үзэж байх хэрэгтэй” хэмээн заажээ.

Төрийн албан хаагчид нь “Үйл ажиллагаа явуулахдаа засгийн газрын хаалттай мэдээллийг ашиглах, эсвэл тийм төрлийн мэдээллийг хувийн зорилгод ашиглах тийм санхүүгийн үйл ажиллагаанд оролцох ёсгүй”.

Ямар нэгэн хэлбэрээр өргөл барьц авах эсвэл ажилтны ажиллаж байгаа тухайн байгууллагын зохицуулж буй үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа эсвэл тэдэнтэй ямар нэгэн нийтлэг нэг үйл ажиллагаанд ямар нэгэн албан ёсны үйлдэл хийлгэхийг

хүсэж байгаа этгээдээс эсвэл бүлэг этгээдээс бэлэг авах зэргийг ямар нэгэн хэлбэрээр өөгшүүлэхийг албан хаагчдад хатуу хоригложээ. Мөн түүнчлэн эдгээр албан хаагчдын албан тушаалын үүрэг хариуцлагаа зохих ёсоор биелүүлэх эсвэл биелүүлэхгүй байхаас ихээхэн хэмжээгээр ашиг сонирхол нь хамаарч байгаа этгээдүүдээс бэлэг шан харамж авахыг зөвшөөрөхгүй болно.

Албан хаагчдын үүрэг хариуцлагад “өмч хөрөнгө үрэгдүүлэх, хууран мэхлэх, албан тушаалаа хэтрүүлэн ашиглах ба авлига зэргийн талаар мэдэгдсэн бүх тохиолдлуудын талаар зохих байгууллагуудад ” илтгэж байхаар оруулжээ.

Үндсэн (албан тушаалын) цалингаас илүү нэмэгдэл орлого олох боломжийг уламжлал ёсоор хязгаарлажээ. АНУ-ын Ерөнхийлөгчийн томилдог албан тушаалтнууд нь өөрсдийн шууд хариуцах албаны үүрэг хариуцлагын хүрээнээс хальсан үйл ажиллагаа болон үйлчилгээнийхээ төлөө алба хаах бүх хугацааныхаа туршид орлого олох ямар ч боломжгүй болсон байна.

Дээр дурдсан тушаалаас гадна 1978 оны АНУ-ын төрийн албан хаагчдын ёс зүйн хууль бас Америкийн түшмэлүүдийн санхүүгийн мөнгөн орлогын мэдүүлгээ өгөх журамд оржээ.

Энэхүү гүйцэтгэх тушаал ёсоор Цагаан ордны албан хаагчид болон бусад гүйцэтгэх засаглалын байгууллагуудын (§100.735-24) бүх албан хаагчид өөрсдийн байгууллагуудын удирдлагуудад хавсрагдсан маягтаар дараахь мэдээллийг тухайн тушаал хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 90 хоногийн дотор гарган өгсөн байхыг хатуу заасан байна:

- а) Бүх корпораци, компани, пүүсүүд ба бизнесийн бусад хэлбэрийн байгууллагын мөн түүнчлэн тухайн үед албан хаагч өөрөө эсвэл эхнэрээрээ, насанд хүрээгүй хүүхдээрээ эсвэл гэр бүлийн бусад гишүүдээрээ дамжуулан харьцаж байгаа ерөнхий боловсролын ба бусад дээд сургуулиудын нэрсийн жагсаалтыг гарган өгөх.

Тухайн тохиолдолд “харьцах” гэсэн ойлголтод “аливаа хадгалагдаж байгаа санхүүгийн ашиг сонирхол ба ямар хэлбэр нь хамаагүй албан тушаалтнуудын эдгээр байгууллагуудтай тогтоосон холбоо сүлбээ” зэргийг ойлгоно.

- б) Хавсрагдсан маягтаар бол албан хаагч өөрийн болон эхнэрийн, бага насны хүүхдүүдийн ба хамтран амьдарч байгаа гэр бүлийн бусад гишүүдийн зээлдүүлэгчдийн жагсаалтыг гарган өгөхийг албан тушаалтнуудаас шаардана.
- в) Дээр дурдсан бүх этгээдүүдийн үл хөдлөх хөрөнгийн талаар мэдээлэл.
- г) Өөрийн үйлчилж байгаа арилжааны, санхүүгийн ба бусад сонирхлуудын талаар мэдээлэл.

Шалгалтыг аливаа улсын төр засгийн удирдлагын эсвэл удирдах газрын тусгайлан томилсон этгээдүүд эсвэл бүлэг этгээдүүд, комиссынхон хийх бөгөөд эдгээр томилогдсон этгээдүүд нь шаардлагатай тохиолдолд албан хаагчдаас нэмэлт мэдээлэл гарган өгөхийг хүсэх, албан тушаалтнуудыг өөрсдийн ярилцлагад дуудах, мөрдөн байцаалт явуулах зэрэг үйл ажиллагаа явуулж болно. Албан тушаалтнуудын хувьд тэдгээрийн гаргасан зөрчлүүдийн үр дагавар нь дараахь нөлөөлөх арга хэмжээнүүдийн аль нэгийг түүнд хэрэглэх хэлбэрээр илэрч болох юм:

- Хэсэгчилэн эсвэл бүрэн хэмжээгээр хасах
- Доош нь бага албан тушаалд бууруулах
- Харшлах санхүүгийн холбоог зогсоохыг санал болгох.

Ноцтой зөрчил гаргавал эрүүгийн хариуцлагад татаж болно.

ХБНГУ-д тухайн онцлог үүргээс үл хамааран улсын албан хаагчид нь өөрийн зорилгоо үнэнч шударгаар биелүүлэх үүрэгтэй бөгөөд бүх нийгмийн сайн сайхныг зорилгоо болгоно. Улсын албан хаагч нь албан үүргээ гүйцэтгэх асуудлаар өөрийн үйлдлүүдийн хууль ёсны бүрэн хариуцлагыг үүрдэг. Албаны заавар журмын хууль ёсных эсэхэд эргэлзвэл энэ тухайгаа албан хаагч нь өөрийн дээд удирдлагад шууд нэн даруй мэдээлэх ёстой. Хэрэв тушаал захирамж нь хүчин төгөлдөр хэвээр үлдэн эргэлзээ арилахгүй байгаа бол уг албан хаагч нь дээд удирдлагын даргадаа хандах ёстой. Хэрэв бас энэ дарга тушаал захирамжийг баталвал уг захирамж нэгэнт тогтсон журамд харшлахгүй тохиолдолд албан хаагч нь түүнийг биелүүлэх ёстой болно. Хэрэв хүсэлт гаргасан бол энэ тохиолдолд захирамжийг баталсан тухайгаа бичгээр өгсөн байх ёстой.

Авлигатай тэмцэх тэмцлийн бодит хэлбэр бол албаны нууцыг хадгалах явдал юм. ХБНГУ-д улсын албан хаагч нь алба хаах хугацаа дууссаны дараа өөрийн үйл ажиллагааны явцад түүнд илэрхий болсон мэдээлэл ба баримтуудын нууцыг хадгалах ёстой. Улсын албан хаагч нь зөвшөөрөлгүйгээр мэдүүлэг өгөх, эсвэл өөрийн мэдэх баримт материалын талаар мэдэгдэл хийх зэрэг эрхгүй тэрчбайтугай шүүх дээр ч хориглодог. Энэ төрлийн зөвшөөрлийг албаны дарга эсвэл тухайн албаны харилцаа зогссон бол дараагийн албаны дарга өгөх болно. Хэвлэлд зориулсан мэдээллийг зөвхөн байгууллагын захиргаа эсвэл эрх олгогдсон албан хаагч өгөх эрхтэй болно. Албан хаагч нь өөрт мэдэгдсэн эрүүгийн хуулиар шийтгэгдэх хэмжээний үйлдлийн талаар илтгэх үүргийг хүлээлгэдэг.

ХБНГУ-д улсын албатай холбогдуулан өндөрссөн шаардлагууд болон хязгаарлалтууд нь зохих ёсны цалин хөлс ба бусад төлбөрүүдээр, албан тушаал ахих ба ажлын байрны тогтвортой байдал мөн түүнчлэн амьдралын боломжтой түвшинг хангах батламжуудаар нөхөн олгогддог.

ХБНГУ-д улсын албан хаагчдад албаны ажлаас өөр ямар нэгэн өөр ажил хийхэд дээд байгууллагын урьдчилсан зөвшөөрөл шаарддаг. Зөвшөөрлийг зөвхөн: асран

хамгаалах, өвчтөн эсвэл ядарсан хүмүүсийг асрах, гэрээслэлийн гүйцэтгэл хэрэгжүүлэх, чөлөөт мэргэжлийг сонгох, өөрийн өмч хөрөнгийг захиран зарцуулах, шинжлэх ухааны хүрээлэн байгууллагуудад судалгаа шинжилгээ болон сургалтын үйл ажиллагаа эрхлэх зэрэгт авах шаардлагагүй байдаг. Улсын албан хаагч нь ямар нэгэн бизнесийн үйл ажиллагааг өөрөө хувиараа болон бусдаар дамжуулан эрхлэх эрхгүй, мөн түүний дотор аливаа хууль эрх зүйн дурын хэлбэрийн аж ахуйн газар эсвэл нийгэмлэг, нөхөрлөл зэрэгт эсвэл ажиглах зөвлө болон удирдлагын үйл ажиллагаанд оролцох эрхгүй байна.

Улсын албан хаагчдын аил хавсран гүйцэтгэх журмын талаархи дэлгэрэнгүй жагсаалтыг хууль эрх зүйн хүчин төгөлдөр тогтоол гаргах замаар холбооны засгийн газар нийтлүүлдэг. Эдгээр тогтоолуудад ямар үйл ажиллагааг нь улсын алба гэж үзэх, эсвэл түүнтэй адилтгаж үзэх; дагалдах үйл ажиллагааны төлөө улсын албан хаагч нь шан харамж авах эрхтэй юу, ямар зэрэглэлийн албан хаагчид зөвшөөрөл авах ёстой гэх зэрэг нь тодорхойлогддог. Жишээ нь: засгийн газрын 1987 оны 11-р сарын 12-ны тогтоолоор албаны болон түүнээс гадуур хэрэгжиж байгаа эсэхээс үл хамааран үүрэг хариуцлагын үндсэн хүрээнд хамрахгүй байгаа аливаа үйл ажиллагааг дагалдах үйл ажиллагаа гэжээ. Хүндэтгэлийн үүрэг хариуцлагын аливаа гүйцэтгэл нь тиймэрхүү үйл ажиллагаанд тооцогддоггүй. Дагалдах хавсралт үйл ажиллагааны төлөөх шан харамж бол аливаа мөнгөн дүн эсвэл аливаа материалын урамшуулал юм. Албан хаагчдын янз бүрийн ангилалд зориулан хуанлийн жилийн урамшууллын хэмжээний хязгаар ба түүнийг тооцох журмыг тодорхойлсон байна.

Хэрэв албан тушаалын эрхзүйн харилцаагаа дуусгасны дараа улсын албан хаагч нь сүүлийн таван жилийн хугацаанд эрхэлж байсан албан ажилтай холбоотой үйл ажиллагаа эрхлэх бол уг албан хаагч энэ тухай сүүлчийн ажиллаж байсан газартаа мэдэгдэх ёстой. Хэрэв энэ ажиллагаа нь албаны ашиг сонирхолд хохирол учруулах эрсдэл байгаа бол түүнийг тухайн үйл ажиллагааг эрхлэхийг хориглоно. Хоригийг албан хаагчийн хамгийн дээд талын байгууллага гаргах бөгөөд албаны хууль эрх зүйн харилцаа дууссанаас хойш таван жил өнгөрөх үед хүчин төгөлдөр бус болно.

Улсын албан хаагч түүнд хариуцуулсан үүрэг хариуцлагаа биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүйгээс үүдсэн хор уршиг зэргийг дэлгэрэнгүй зохицуулсан байна. Хэрэв албан хаагч нь түүнд хариуцуулсан үүрэг хариуцлагаа биелүүлэхээ зөрчсөн буруутай бол улсын албан хаагч (Холбооны сахилгын эрх зүйн дүрмээр) нь албаны алдаа гаргасан гэж тооцогдоно. Гэхдээ үүрэг хариуцлагын зөрчил бүрд нь хариуцлагын арга хэмжээг хэрэглэхгүй юм байна. албан ажлын алдаа дутагдал гаргасаны төлөө хариуцлага татах журмыг дэлгэрэнгүй зааж өгчээ. (сахилга батын процесс). Алдаа дутагдал болон бусад үндэслэлээр албанаас халах журам нь Улсын албан хаагчдын хууль эрх зүйн байдлын ерөнхий хууль ба Холбооны албан хаагчдын хууль зэрэгт тусгагдсан байна.

Харин энэ талаар Орост байдал ямар байна вэ? 1995 онд гаргасан “ОХУ-ын улсын албаны үндсийн тухай” холбооны хууль-г үзвэ. Энэ хуулийг их хүндрэлтэйгээр боловсруулсан бөгөөд бараг таван жилийн турш хэлэлцэгдсэн байна. Түүний 11 ба 12-р заалтуудад улсын алба хааж байгаа түшмэлүүдэд чухал хязгаарлалтуудыг тусгасан, тэдгээрээр жил бүр хөрөнгийнхээ мэдүүлгийг өгч байх үүргийг хариуцлага болгон тодорхойлсон байна. Хязгаарлалтын 12 зүйлүүдээс 10-т нь авлигаас урьдчилан сэргийлсэн арга хэмжээнүүдийг тусган зааж өгсөн байна. Гэвч энэ хууль ерөнхийлөгчөөр батлагдан өмнө нь үйлчилж байсан Холбооны албаны тухай тогтоолын нэгэн адил зөвхөн улсын үйлчилгээний албан хаагчид (төрийн албаны “Б” ба “В” зэрэглэлийн албан хаагчдад)-д хамаарах юм. Энэ хуулийн хүрээний гадна төрийн “А” зэрэглэлийн албан тушаалтнууд, хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын удирдлагууд, депутатууд, сайд нар, шүүгчид болон бусад олон холбооны ба бүс нутгийн түвшний өндөр албан тушаалтнууд үлдэж байгаа юм. Нэрлэгдсэн зэрэглэлүүдийн албан тушаалтнуудын өмчийн байдлыг хянахаар заагдсан хяналт нь зөвхөн тэднийг өөрсдийг нь хамрах бөгөөд харин тэдний ойрын садан төрлийнхнийг хамрахгүй байгаа ба авлигачид авч байгаа өмчөө өөрийнхөө нэр дээр авдаггүй нь илэрхий байгаа юм.

Парламент дахь авлигын асуудал

Баруунд парламентын авлигатай тэмцэх тэмцэлд төрийн албан хаагчдын дундах авлигатай тэмцэх тэмцлээс багагүй анхаарлаа хандуулж байна. гэтэл манай улсад энэ чиглэл хууль тогтоогчдын анхаарлаас гадуур үлдэж байна. Үнэн хэрэгтээ зохих хууль тогтоомжийг гаргах асуудал нь Холбооны зөвлөлийн гишүүд ба депутатуудаас өөрийгөө ихээхэн золиослох зовоох асуудлыг шаарддаг билээ.

Канадын хууль тогтоомжууд нь улс орны улс төрийн амьдралд оролцох бизнесийнхний эрхийг ялангуяа парламентын сонгуулийн үеэр тодорхой хэмжээгээр хүлээн зөвшөөрөхийн хамт (энэ чиглэлээр Оросын хууль тогтоомжуудыг бодвол арай илүү чөлөөт байдаг), энэхүү оролцоо нь хатуу тогтоосон хүрээнд байхаар чиглэгдсэн байдаг. Бизнесийн ертөнцтэй холбогдсон парламентынхны холбоо нь орчин үеийн Канадад захиргаа-хууль зүйн маш нарийн зохицуулалтын объект болдог бөгөөд юуны түрүүнд депутатын болон ажил хэрэг эрхлэх менежерийн үүрэг хариуцлагуудыг хавсран гүйцэтгэх, үнэт цаас эзэмших, сонгуулийн өмнөх кампанит ажилд зориулан мөнгө хүлээн авах ба тэдгээрийн зарцуулах зэрэг нь тус зохицуулалтын объект болж байдаг. Парламентын гишүүдийн улс төрийн болон эдийн засгийн эрх ашиг сонирхол мөргөлдсөн тохиолдолд парламентын гишүүдийн бие авч явах байдалд хууль тогтоогчдоос тавих шаардлагуудын чухал бүрэлдэхүүн хэсгүүд бол ил тод байдал ба тайлагналт юм.

Канадад парламент дахь авлигын эсрэг хууль тогтоох арга хэмжээнүүдийг эрүүгийн болон үндсэн хуулийн эрхийн нормуудаар тогтоодог. Тэдгээр нь парламентын хоёр танхимын бүх гишүүд ба мөн түүнчлэн засгийн газарт ч хамаардаг.

Канадын эрүүгийн хууль нь парламентын авлига-хээл хахуулийг үндсэн хууль зөрчих ба улс орноосоо урвахтай адилтгаж үздэг. Хээл хахууль авсан хүнийг болон өгсөн хүнийг хоёуланг нь эрүүгийн шийтгэлээр шийтгэдэг. Энэ тохиолдолд парламентын гишүүнд 14 жил хүртэл хугацаагаар хорих ял оноодог бөгөөд тэгэхдээ энэ гишүүн автоматаар пдарламентын гишүүний мандатаа шүүхэд буруутай нь тогтоогдсон өдрөөс эхлэн алдана. Канадын Үндсэн хуулийн эрх зүй (тухайлбал Парламентын тухай хууль ба Парламентын бүтэц) нь парламентын гишүүний өмнөх ажлын төрлийн ажил хэргийн янз бүрийн төрлөөс урган гарах улс төрийн болон эдийн засгийн эрх ашиг, сонирхлын зөрчил гарах үед парламентын гишүүний биеэ авч явах байдалд хамаатай зөвлөмжүүд ба дүрмийг агуулдаг байна. энэхүү нормууд нь бизнесээс парламент хараат байхын эсрэг болон депутатууд хувийн ашиг сонирхолдоо албан тушаалаа ашиглахын эсрэг чиглэсэн байна.

Парламентын жирийн гишүүд үнэт цаас эзэмших, захиран зарцуулах, корпорациудад албан тушаал эзэмших эрхээ албан ёсоор хадгалах боловч энэхүү зөвшөөрөл нь нөхцөл байдлыг зохицуулах бөөн зохицуулалтаар хүрээлэгдсэн байна. бүх депутатууд нь жил бүр бичгээр өөрсдийн захиралаар, менежрээр эсвэл албан хаагчаар ажиллаж байгаа компаниудын тухай мэдээлж байх мөн түүнчлэн үнэт цаасыг нь эзэмшиж байгаа корпорациуд, сангуудын талаар мэдээлэх: үүнд пүүсүүдийн хаяг, тэдгээрийн үйл ажиллагааны ерөнхий шинж чанар, хөрөнгийн эргэлт, орлогын байдал, засгийн газрын гэрээнүүдэд оролцож байгаа байдал, экспорт ба импортын тухай зэрэг мэдээллүүд байх болно. Канадын засгийн газрын гэрээтэй корпорациудын үйл ажиллагаанд оролцохыг зөвхөн анх удаа парламентад сонгогдож байгаа гишүүдэд, тэгэхдээ тухайн гэрээний ажил нь жил бүр 1000 доллараас хэтрэхгүй дүнтэй тийм нөхцөлд зөвшөөрдөг байна. Парламентад хоёр ба түүнээс илүү хугацаагаар сонгогдож байгаа гишүүд нь засгийн газрын гэрээг хэрэгжүүлэхтэй ямар нэгэн хэлбэрээр харьцах эрхгүй байна. тогтоосон нормыг зөрчих нь 10 мянган доллар хүртэл торгуулийн шийтгэлтэй байна. Үүнээс гадна хуулиас гадуур засгийн газрын гэрээний биелэлтээс ашиг олсон депутат 30 хоногийн хугацаанд дурдсан хэмжээний мөнгийг улсын санд буцаах, цаашдаа гэрээнд оролцохоос татгалзах болон корпорацийн удирдлагаас шарах үүрэг хүлээнэ. Ингэхгүй бол гишүүн нь парламентын суудлаасаа хасагдан энэхүү суудал нь автоматаар чөлөөтэй болдог.

Заагдсан хязгаарлалтууд байгаатай холбогдуулан орчин үеийн канадын парламентын гишүүд улс төрд орсоноосоо хойш ажил хэргийн үйл ажиллагаа явуулахгүй байсан нь дээр гэж үздэг болсон байна. тэдгээрийн зарим нь нэг нь дагалдах ажил хэрэг-хууль зүйн эсвэл анагаах ухааны чиглэлийн ажлыг давхар хийдэг. Эдгээр нь бизнесийн онцлог төрөлд тооцогдож болдог юм. Депутатуудын нэг хэсэг нь бага хэмжээний хувьцааг ихэвчлэн гэр бүлийн пүүсүүдэд эзэмшдэг байна.

Үүнээс илүү хатуу хязгаарлалтууд засгийн газрын гишүүдийн хувьд үйлчилдэг. Засгийн газрын бүрэлдэхүүнд томилогдсон бүх этгээдүүд корпорациудын захиргаанаас болон бүх олон нийтийн байгууллагуудын удирдах бүрэлдэхүүнээс нэн даруй гарах ёстой. Ийнхүү эдгээр тогтоомжууд нь засгийн газар ба бизнесийн хоорондын нийлэлтийг хориглож байдаг юм.

Хэрэв жишээлбэл, шинээр томилогдсон сайд нь хувьцаа эзэмшиж байгаа бол хууль түүний хувьд дараахь арга хэмжээг зааж өгсөн байна: хувьцааг бүгдийг нь худалдах, хувьцааг “сохор сан” гэж нэрлэгддэг санд оруулах, хувьцааны тухайн үеийн үнийн ерөнхий мэдээллүүдээс бусад түүний үнэт цаастай холбоотой үйл ажиллагааны талаархи мэдээллийг удирдлагаас авахаас татгалзах, хувьцааг “царцаах сан”-д оруулах, үнэт цаасыг үндэсний орлогын яаманд бүртгэж авах тэгэхдээ бүртгүүлсэн баримт бичгүүдийг нээлттэй болгон тэдгээртэй Канадын дурын иргэн танилцах боломжтой болгох. Энэ тохиолдолд тухайн сайд үнэт цаасыг худалдах, худалдан авах, ашиг авах боломжтой боловч заагдсан яманы албан тушаалтнуудын тогтмол хяналтын дор тэдний зөвлөгөөгөөр гүйцэтгэх болно. Бодит амьдрал дээр канадын сайд нар ихэнхдээ нэг ба хоёр дугаар хувилбаруудыг ашигладаг.

Авлигаас урьдчилан сэргийлэх ба ажил хэргийнхний хүрээлэл болон бусад бүлгүүдтэй харьцах харьцаан дахь парламентын гишүүдийн эрх чөлөөг хязгаарлахад чиглэсэн хэд хэдэн норм актууд сонгуулийн тухай хуулинд агуулагддаг.

Энэхүү хууль нь сонгуулийн кампанит ажлын үед парламентад нэр дэвшигчдийн зарцуулж болох хамгийн их боломжит нормыг тогтоож өгсөн байна. Эхний 15000 сонгогчтой тойрогт хүн тус бүрд 1доллараас ихгүй, дараагийн тойргуудад хүн тус бүрт 50 центээс ихгүй, заагдсан тоо хэмжээнээс хэтэрсэн үед сонгогч нэг бүрт 25 центээс хэтрэхгүй хэмжээний зардал ашиглахыг нэр дэвшигчдэд зөвшөөрдөг. Ингэхдээ хэвлэл мэдээллийн хүрээнд зар сурталчилгаанд гаргасан нэр дэвшигчийн зардлыг хэсэгчилэн (22.5%) төсвөөс нөхөн олгодог. Корпорацийг оролцуулан аливаа биет болон хуулийн этгээд нэр дэвшигч болон түүний намын санд 50000-аас ихгүй долларын хандив оруулах эрхтэй байх боловч төрөөс хувийн хэвшлийнхний хандивыг 100 ам.долларын хязгаарт хөнгөлөн, энэ хэмжээний дүнгийн ихэнх хэмжээний дүнг нөхөн олгодог.

Сонгуулийн тухай хууль нь нэр дэвшигчид болон тэдгээрийн намын дэлгэрэнгүй тайланг заавал авахыг заах бөгөөд Үүнийг Үндэсний сонгуулийн хороо гаргуулан авдаг. Тухайлбал эдгээр тайлангуудад 100 доллараас дээш хэмжээний хандив төлөгдөх бүх эх үүсвэрүүдийг ил тусгах ба тайлан нь хуулийн баталгааг чек, ба гарын үсэг хэлбэрээр гаргасан байх ёстой.

Сонгуулиас хойш зургаан сарын хугацаанд заасан тайланг гарган өгөөгүй нэр дэвшигчид ба намууд нь шүүхээр хэлэлцэхгүйгээр автоматаар шууд улсаас авах бүх төлбөрөө хасуулах ба нэр дэвшигчид нь үүнээс гадна цаашдаа парламентад нэр дэвших эрхээ хасуулна. Сонгуулийн тухай хуулийн бусад зүйл ангийг зөрчих нь

жишээ нь хууль тогтоомжоор тогтоосон зарцуулалтын хязгаар, мөнгө цуглуулах ба санхүүгийн баримт бичгийг хөтлөлт зэргийг нэр дэвшигчийн тусгай төлөөлөгч биш нэр дэвшигч өөрөө хэтрүүлбэл 25000 хүртэл долларын торгууль төлөх эсвэл 5 жил хүртэл шоронд хорих шийтгэл тусгагдсан байна.

АНУ-д АНУ-ын Конгрессын Сенатын ёс зүйн хууль ба АНУ-ын Конгрессын Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн ёс зүйн хууль (1977 оны) зэрэг хуулиуд үйлчилдэг. Эдгээр хууль эрхийн үйлчлэл нь Конгрессын гишүүд төдийгүй аппаратын ажилтнуудад ч хамаарна.

Санхүүгийн байдлаа мэдүүлэх журам нь ч сонирхол татаж байна. дээд танхимын хувьд тусгай маягтын хавсралтуудыг Сенатын ёс зүйн хороо боловсруулан гаргадаг. Мэдүүлгүүдийг Сенатын Нарийн бичгийн даргын газарт гарган өгдөг (тэрч байтугай өрөөний дугаар тавигдана-SH-232). Сенаторууд, Сенатад нэр дэвшигчид (эрс тэрс гэвч ялангуяа “Климентьевын синдром”-той холбоотойгоор бол үр дүнтэй шаардлага гэж үзэх хэрэгтэй), мөн түүнчлэн Сенатын янз бүрийн түвшний албан тушаалтнууд, Сенатын албан хаагчид хүртэл санхүүгийн мэдүүлгээ гарган өгөх үүрэгтэй. Мэдүүлгийг жил бүр гаргах бөгөөд нэр дэвшигчидийн хувьд бол нэр дэвшүүлснээс хойш 30 хоногийн дотор гарган өгнө. Өнгөрсөн жилийн хугацааны санхүүгийн орлого ба зарлагатай холбоотой бүгдийг мэдүүлнэ:

- Бүрэн цалин, хувьцааны ашиг, хадгаламжийн хүү, хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийн орлого, гонорарууд;
- Санхүүгийн ба засгийн газрын бус байгууллагуудаас олсон бусад орлогууд;
- Тээврийн төлбөрүүд түүнтэй холбоотой зарлагууд;
- Дурын этгээд ба байгууллагуудаас авсан бэлэгнүүд, түүний дотор тээврийн зардлын төлбөр хэлбэрээр, хоол хэлбэрээр, зочид буудлын төлбөр, ресторанд дайлуулах, төрөл бүрийн зугаа цэнгэл хэлбэрээр;
- Санхүүгийн болон бусад үүргүүд, тэдгээрийн төлбөр;
- Янз бүрийн байгууллагуудтай тэдгээрт эсвэл тэдгээрийн төлөө ажиллахаар хийсэн гэрээ хэлэлцээр ба тохиролцоо болон бусад олон зүйлс;

Гадаадын засгийн газрууд, гадаадын байгууллагууд болон гадаадын иргэдээс бэлэг хүлээн авах зэрэгт онцгой анхаарал хандуулна. Жишээ болгоход:

Хэрэв сенатор эсвэл албан хаагч нь гадаадын засгийн газраас, байгууллагаас, пүүс компанийн төлөөлөгчөөс эсвэл хувь этгээдээс 100 доллараас дээш үнэлэгдэх хэмжээний бэлэг авсан бол, авсан бэлгээ 60 хоногийн дотор Сенатын нарийн бичгийн газарт илгээх ёстой. Уг албан хаагч эсвэл сенатор нь бэлэг авсан тухайгаа тайлбар бичгийг хоёр хувь үйлдэх ёстой. Нэг хувийг Менатын ёс зүйн Тусгай хороонд харин нөгөө хувийг авсан бэлгийн хамт Сенатын нарийн бичгийн даргын газар руу илгээнэ.

Тайлбар бичгийг дурын хэлбэрээр хийх боловч бэлэг авагчийн нэр ба албан тушаал, бэлэгний тухай товч тайлбар, мөн түүнчлэн бэлэг авсан шалтгаан ба нөхцөл

байдал, гадаадын ямар улс орны засгийн газар ба эсвэл этгээд (Хэрэв тодорхой бол) бэлэг өгсөн, бэлгийн ойролцоо үнэлэмж, (бэлэг хүлээн авсан өдрийн байдлаархи АНУ дахь үнэ) болон бэлэг хүлээн авсан огноо зэргийг заавал агуулсан байх ёстой. Үүнтэй адил өгөгдлүүдийг хувийн зорилгоор гадаадад айлчлах эсвэл дотоодод аялан явах үед тээврийн зардлаа төлүүлэх хэлбэрээр бэлэг хүлээн авсан бүх тохиолдлуудад гарган өгөх ёстой болно.